

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 03 ДУГААР САРЫН

2 ДАХЬ ДОЛОО ХОНОГИЙН МЭДЭЭ

2018.03.07

|   | Хоногийн товч мэдээ  | Дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал | Бусад асуудал |
|---|--|---|---------------|
| 1 | <p>2013 оны 12- р сарын 20- нд НҮБ- ын Ерөнхий Ассамблейн ( UNGA) 68 дахь чуулганаараа 03-р сарын 03-ны өдрийг "НҮБ-ын Зэрлэг амьтан хамгаалах өдөр" байхаар тогтжээ. Иймд Дэлхийн амьтан, ургамлыг хамгаалах өдөрт зориулсан "Ирвэст учирч буй аюул занал" үйл ажиллагааг МАНУТХГХЗахиргаа, ХИС-ын Б-Ө аймаг дахь салбар сургуулиудтай хамтран дэлхийд ховордсон амьтан Ирвэсийн талаар мэдээллийг түгээх зорилгоор аймгийн төвийн бүх ЕБСургуулиудын сурагч, оюутнуудад сургалт зохион байгуулж, орон нутгийн радио, телевизээр амьтны хууль тогтоомжуудыг сурталчилах ажлуудыг зохион байгууллаа.</p>   |   |               |
| 2 | <p>Аймгийн Цагдаагийн газартай хамтарч "Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд орон нутгийн иргэдийн оролцоо" сэдэвт сургалт, зөвлөөгөөнийг Баяннуур сумын нутгийн ард иргэдэд зохион байгуулж, Байгаль орчны хууль, тогтоомжийн талаар мэдээлэл тавьж, иргэдийн асуусан асуултад хариулт өгч, мэргэжлийн арга зүйн зөвлөөгөө өглөө.</p>   |   |               |
| 3 | <p>Өвлийн аялал жуулчлалыг улсын хэмжээнд хөгжүүлэх зорилтын хүрээнд Байгаль орчин аялал жуулчлалын яам, Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Нийслэлийн аялал жуулчлалын газар, Улаанбаатар Хотын Аялал Жуулчлалын Холбоо, Монголын бүргэдчдийн холбоо, Баян-Өлгий аймгийн Нутгийн зөвлөл хамтран “Бүргэдийн баяр”-ыг Улаанбаатар хот “Чингисийн Хүрээ” жуулчны баазад 11 дэхь жилдээ зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Баян-Өлгий аймгаас 21 бүргэдчидийг оролцуулж, бүргэдээр ан хийх, көкпар буюу тулам булаацалдах, газраас зоос шүүрэх зэрэг казах ардын уламжлалт тоглоомуудыг гадаад дотоодоос ирсэн 8000 гаруй жуулчдад сонирхууллаа.</p> |   |               |

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

